



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13




## Монгол Улсаас 2022 оны 1 дүгээр улиралд БНСУ-д 377 иргэн, Япон Улсад 26 иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажиллахаар зуучлагдсан байна

Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн тоо өмнөх улирлаас 249 (2.6 дахин) хүнээр өссөн байна. Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн 357 (88.6%) нь эрэгтэй, 46 (11.4%) нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн хамгийн их буюу 42.4 хувь нь 30-34 насныхан, 25.1 хувь нь 25-29 насныхан байгаа бол хамгийн бага буюу 0.7 хувь нь 45-49 насныхан байна.

ЗУРАГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР ГАДААД УЛСАД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД,  
2022 оны 1 дүгээр улирлын байдлаар, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар



Хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлстэй ажил эрхлэхээр зуучлагдсан иргэдийн 181 (44.9%) нь бүрэн дунд, 170 (42.2%) нь бакалаврын дээд, 51 (12.7%) нь техникийн болон мэргэжлийн, 1 (0.2%) нь магистр, доктор боловсролтой байна. Хөдөлмөрийн гэрээгээр зуучлагдсан иргэдийн 377 (93.6%) нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 23 (5.7%) нь хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны салбарт, 3 (0.7%) нь мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажил эрхлэхээр зуучлагджээ.

### Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүмүүс юм.



**Эх үүсвэр:**

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 7 дугаар сарын 19

Нийгмийн статистикийн газрын

дарга А.Амарбал

Утас : (976-51)-264805

Нийгмийн статистикийн газрын Өрхөд

суурилсан судалгааны хэлтсийн статистикч

Б.Лхагвасайхан

Утас : (976-51)-265543

